

2008.04.18

Дугаар 99

”Гермес центр” ХХК-ийн нийтэд санал болгон
гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 3.1 дэх заалт болон “Гермес центр” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2008 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.“Гермес центр” ХХК-ийн 2008 оны хувь нийлүүлэгчдийн хурлын 02 дугаар тогтоолоор хувьцаат компани болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 54980101 ширхэг хувьцаанаас “Гермес центр” ХХК-ийг үүсгэн байгуулагч иргэн Д.Зоригтын нэр дээр 31338657 ширхэг, иргэн М.Түмэнжаргалын нэр дээр 20892438 ширхэг, иргэн Т.Гансүлдийн нэр дээр 2749006 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг тус тус үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2.“Гермес центр” ХХК-ийн 2008 оны хувь нийлүүлэгчдийн хурлын 02 дугаар тогтоолыг үндэслэн тус бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 23562900 ширхэг хувьцааг нийтэд санал болгон Хөрөнгийн биржээр арилжаалахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолын 1-д заасан нэр бүхий үүсгэн байгуулагч иргэдийн өмчлөлд бүртгэсэн хувьцааг үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс 1 жилийн хугацаанд тусгаарлаж арилжаанд оруулахгүй байхыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгоосугай.

4.Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас нийтэд санал болгох 23562900 ширхэг хувьцааг үнэт цаасны анхдагч зах зээлд зохих журмын дагуу арилжиж дууссаны дараа Хорооноос зөвшөөрөл олгох хүртэл хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг нээхгүй, хоёрдогч зах зээлтэй холбогдох гүйлгээг гүйцэтгэхгүй байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

5.“Гермес центр” ХХК нь хэлбэрээ өөрчлөн ХК болж буйгаа Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэхийг “Гермес центр” ХХК /Т.Гансүлд/-д даалгасугай.

6.Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг зохих журмын дагуу нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангаж, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн хуулиар олгогдсон эрхийг зохих журмын дагуу хангаж, хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Гермес

центр” ХК /Т.Гансүлд/, Андеррайтерийн компани “Батс инвест” ХХК /Л.Жавзмаа/-д тус тус үүрэг болгосугай.

7.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ